



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 20 өдөр

Дугаар А/188

Чингис хот

Объектын гал түймрээс урьдчилан сэргийлэх
ажилд хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өнжмөл шар өвс, хамхуул, хазаар өөснөөс үүдэлтэй объектын гал түймрээс урьдчилан сэргийлэх, гал түймрийн тоо хохирлыг бууруулах, иргэдийн амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгийг аврах ажлыг зохион байгуулж ажиллахыг Онцгой байдлын газрын дарга /хурандаа Ж.Эрдэнэбат/, Хэрлэн сумын Засаг дарга /М.Шүрэнцэцэг/ нарт тус тус үүрэг болгосугай

2. Урьдчилан сэргийлэх ажилд зарцуулагдах хөрөнгийн тооцоог хавсралтаар баталсугай.

3. Дээрх зардалд шаардагдах 5.000.000 /таван сая/ төгрөгийг Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас зарцуулахыг Санхүү, тэрийн сангийн хэлтэс /С.Нямдаваа/-т зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Ц.Чогсомжав/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011229

Аймгийн Заваг даргын 2021 оны
 ... дугаар сарын ... өдрийн ...
 дугаар захирамжийн хавсралт



Урьдчилан сэргийлэх ажилд шаардагдах зардлын тооцоо

Гал унтраах тусгай зориулалтын автомашинуудын 1 өдөрт ажиллах шатахууны тооцоо									
Д/д	Автомашины марк, улсын дугаар	100 км зарцуулах шатахуун норм	1 өдөрт туулах зам	1 өдөрт зарцуулах шатахуун / литр	Насос цагт / литр	1 өдөрт ажиллах насос / цаг	1 өдөрт ажиллах насос /литр	Шатахууны төрөл, үнэ / литр	Нийт шатахууны зардал / төг
1	ГАМ, HOWO 11-05 хэу	55	15	8,25	50	5	250	ДТ, 2100	525,000
2	ГАМ, Маз АЦ- 11 32-00 хэн	52	15	7,8	24	5	120	ДТ, 2100	268,380
3	ГАМ, ЗИЛ-130 АЦ-40 89-02 хэа	45	15	6,75	18	5	90	А-80, 1530	248,000
Дүн		152	45	22,8	92	15	460	-	1,041,380
5 өдөрт ажиллах нийт шатахууны дүн							5,206,900		